




**МОНГОЛЫН  
ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ**

Mongol Securities Exchange

# МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ

**2017 оны үйл ажиллагааны тайлан**





# АГУУЛГА

## 1. КОМПАНИЙН ТУХАЙ

- 1.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал
- 1.2. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгө
- 1.3. Төлөөлөн удирдах зөвлөл
- 1.4. Байгууллагын бүтэц, орон тоо
- 1.5. Дүрэм журам, зохицуулалт

## 2. КОМПАНИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 2.1. Үнэт цаасны бүртгэл

- Дүрэм журам, зохицуулалт
- Бүртгэлийн үйл ажиллагаа
- Маркетинг, олон нийттэй харилцах

### 2.2. Үнэт цаасны арилжаа

- Анхдагч зах зээл
- Хоёрдогч зах зээл
- Арилжааны үе, арга, үнийн хэмжээс, ханшийн хэлбэлзэл
- Зах зээл үүсгэгч
- Арилжааны мэдээ мэдээлэл
- Арилжааны хяналт

### 2.3. Төлбөр тооцоо эрсдэлийн удирдлага

- Тооцооны гишүүн, тооцооны үйл ажиллагаа
- Эрсдэлийн удирдлага
- Мэдээлэл

### 2.4. Мэдээллийн технологи, программ хангамж

## 3. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Санхүүгийн байдлын тайлан
- Мөнгөн гүйлгээний тайлан

## 4. ДҮГНЭЛТ

# 1. КОМПАНИЙН ТУХАЙ

Монголын үнэт цаасны бирж ХК нь (Бирж) 2015 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, үнэт цаасны арилжаа, төлбөр тооцооны олон улсын стандартыг нэвтрүүлэх зорилгоор байгуулагдан Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ны 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 312 тоот тогтоолоор “Үнэт цаасны арилжаа, тооцооны үйл ажиллагаа эрхлэх” тусгай зөвшөөрөл олгосон бөгөөд энэхүү зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хурлын 06 тоот тогтоолоор компанийн хэлбэрийг өөрчлөн “Монголын үнэт цаасны бирж” хаалттай хувьцаат компанийн хэлбэрт шилжээд байна.

## 1.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал

Компанийн тухай хуульд заасны дагуу 2017 онд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 1 удаа, ээлжит бус хурлыг 2 удаа тус тус зарлан хуралдуулж компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн дүгнэлт, ТУЗ-ийн гишүүдийг сонгох, өрийг хувьцаагаар солих, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах, компанийн хэлбэрийг өөрчлөх зэрэг асуудлуудыг хэлэлцэн нийт 7 тогтоол гаргалаа.

## 1.2. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгө

Тайлант хугацаанд Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурлын шийдвэрийн дагуу компанийн өрийг хувьцаагаар солих, санхүүжилт татах зорилгоор нийт 61.7 сая ширхэг хувьцааг эргэлтэд нэмж гаргаснаар 2017 оны жилийн эцсийн байдлаар эргэлтэд гаргасан нийт энгийн хувьцааны тоо 418.7 сая ширхэгт, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 4.18 тэрбум төгрөгт хүрлээ.

Нэмэлт хувьцаа гаргаснаар нийт хувьцааны 84.3 хувийг эзэмшиж байсан Даац инвестмент ХХК-ийн эзэмшил 71.9 хувь, 8.4 хувийг эзэмшиж байсан Даац менежмент ХХК-ийн эзэмшил 7.2 хувь болж буурсан (dilution) бөгөөд бусад 20.9 хувийг нэр бүхий 2 аж ахуйн нэгж, 18 иргэн хамтран эзэмшиж байна.

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг СЗХ-ны “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай зарим үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх журам”-ын 6 дугаар бүлэгт заасны дагуу холбогдох материалыг бүрдүүлэн СЗХ-нд хүргүүлж, Хорооны даргын 2017 оны 389, 478 тоот тушаалуудаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхийг зөвшөөрсөн.

### 1.3. Төлөөлөн удирдах зөвлөл

ТУЗ-ийн хурал 13 удаа, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны хурал 1 удаа, Нэр дэвшүүлэх хорооны хурал 2 удаа тус хуралдсан.

ТУЗ-ийн хурлаар нийт 39 асуудал хэлэлцсэнээс хуралд оролцсон саналын эрхтэй гишүүдийн олонхийн саналаар 34 тогтоол баталсан байна. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах болон хурлын бэлтгэл ажилтай холбоотой 6 тогтоол,
- Компани, ТУЗ, ТУЗ-ийн хороод, Бүртгэлийн хорооны бүтэц, зохион байгуулалттай холбоотой 8 тогтоол,
- Компанийн үндсэн үйл ажиллагаа, санхүүжилт, удирдлага зохион байгуулалттай холбоотой 6 тогтоол,
- Журам шинээр болон шинэчлэн батлах, өөрчлөлт болон нэмэлт оруулахтай холбоотой 6 тогтоол,
- Биржид гишүүн элсүүлэх, чөлөөлөх, урамшуулахтай холбоотой 8 тогтоол тус тус гаргажээ.

ТУЗ-ийн гишүүдийн тоо 2016 онд 7 байсан бол 2017 онд 8 болж өөрчлөгдсөн. ТУЗ-аас энгийн 2 гишүүн өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж, энгийн 1 гишүүнийг түдгэлзүүлж, энгийн 1 гишүүн, хараат бус 3 гишүүн шинээр сонгогдсон. Үүнд:

- 2-р сарын Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн энгийн гишүүн Т.Есүйг өөрийн хүсэлтээр чөлөөлж, энгийн гишүүнээр Б.Түвшин, хараат бус гишүүнээр Б.Аюуш, Б.Лхагважав нарыг шинээр томилсон,
- 10-р сарын Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар ТУЗ-ийн энгийн гишүүн Б.Энхтуяаг чөлөөлж, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Л.Гангэрэлийг томилсон,
- 11-р сарын ТУЗ-ийн хурлаар ТУЗ-ийн энгийн гишүүн М.Бат-Оргилын гаргасан хүсэлтийг хэлэлцэн, хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах хүртэл хугацаанд ТУЗ-ийн гишүүнээс түдгэлзүүлээд байна.

2017 оны 3 дугаар сараас ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар С.Батсүрлэг томилогдож, Компанийн тухай хууль, компанийн дүрмийн холбогдох заалтуудын хүрээнд ТУЗ, ТУЗ-ийн хороод болон хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах, бүртгэл, тэмдэглэл, анкет хөтлөх зэрэг ажлуудыг хариуцан ажиллаж байна.

### 1.4. Байгууллагын бүтэц, орон тоо

ТУЗ-ийн 2017 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 20 тоот тогтоолоор байгууллагын бүтэц, орон тоог 5 алба, 25 хүний орон тоотой шинэчлэн баталсны дагуу 2017 оны жилийн эцсийн байдлаар 18 үндсэн ажилтан, 2 гэрээт ажилтан, нийт 20 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

## 1.5. Дүрэм журам, зохицуулалт

Тайлант хугацаанд дараах чиглэлээр компанийн дүрэмд өөрчлөлтүүд орж, улсын бүртгэлийн байгууллагад шинэчлэн бүртгүүлээ. Үүнд:

- Компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах,
- Компанийн засаглалыг хэрэгжүүлэх чиглэлээр СЗХ-ноос баталсан засаглалын кодексийн заалтуудыг нэмэх,
- Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу компанийн жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэх,
- Холбогдох хууль тогтоомжийн дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүнийг томилон ажиллуулах,
- Хаалттай хувьцаат компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулах.

Үндсэн үйл ажиллагаатай холбоотой дараах журмуудыг шинээр болон нэмэлт өөрчлөлт оруулан баталлаа. Үүнд:

- Тооцооны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам, Дотоод мэдээлэл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавих журмыг батлан, СЗХ-гоор батламжлуулсан.
- Байгууллагын дотоод үйл ажиллагааны буюу Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг шинээр боловсруулан батлав.
- Зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх журамд Хорооноос ирүүлсэн саналын дагуу нэмэлт өөрчлөлт оруулан батлав.
- Монголын үнэт цаасны биржийн бүртгэлийн журамд өрийн хэрэгсэл бүртгэхтэй холбоотой 7 бүлэг, давхар бүртгэлтэй холбоотой 1 бүлэг нийт 8 бүлэг нэмэн, ТУЗ-ийн хурлаар баталж, СЗХ-нд батламжлуулахаар хүргүүлсэн.

2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс арилжаа, тооцооны үйл ажиллагаа албан ёсоор эхэлсэнтэй холбогдуулан өмнө нь батлагдсан журам, практик хэрэглээний хооронд гарч буй зарим асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор үндсэн үйл ажиллагаатай холбоотой бүх журамд нэмэлт өөрчлөлт оруулах төслүүдийг боловсруулж байна.

Хаалттай хувьцаат компани болсонтой холбогдуулан компанийн 418.7 сая ширхэг хувьцааг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд хадгалуулах гэрээ байгуулан компанийн 418.7 сая ширхэг хувьцааг хадгалууллаа.

## 2. КОМПАНИЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 2.1. Үнэт цаасны бүртгэл

Шинэ бүтцийн дагуу үнэт цаасны бүртгэлтэй холбоотой үйл ажиллагааг Бизнес хөгжлийн алба хариуцан гүйцэтгэж байна.

#### *Дүрэм журам, зохицуулалт:*

Тайлант хугацаанд Бүртгэлийн гэрээ, Бүртгэлийн гэрээний Ерөнхий нөхцөл, зөвлөх сонгох болон бүртгэлийн баримт бичиг бэлтгэх удирдамжийн төсөл, үнэт цаас бүртгүүлэх гарын авлага зэрэг баримт бичгүүдийг боловсруулсан.

Биржийн дүрэм, журам, гэрээний загварууд, Биржийн үйл ажиллагааны холбогдолтой СЗХ-ноос гаргасан журмуудын төсөл, Бүртгэлийн журам, уг журмын хавсралтуудад нэмэлт өөрчлөлт оруулах, санал өгөх ажлуудыг гүйцэтгэлээ.

#### *Бүртгэлийн үйл ажиллагаа:*

Монголын үнэт цаасны биржийн бүртгэлийн журам, Бүртгэлийн хорооны үйл ажиллагаа, түүнд хяналт тавих журмын хүрээнд Монголын үнэт цаасны биржид үнэт цаас бүртгүүлэх сонирхолоо илэрхийлсэн Анд-Энерги, Атмор, Аметрос, Дэлгэрэх хүнс, Түмэн шувуут, Минж пропертис, Ариг сувд компаниудын удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудтай уулзан Биржийн үйл ажиллаганы онцлог, давуу тал, хөнгөлөлт урамшууллын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхийн зэрэгцээ тухайн байгууллагын түүх, үйл ажиллагаа, санхүүгийн мэдээлэл, цаашдын хөгжлийн талаар мэдээллүүдийг сонсож шаардлагатай зөвлөгөөг өгч ажиллалаа.

Биржийн бүртгэлийн зарим шалгуураас чөлөөлүүлэх тухай Анд-Энерги, Атмор компаниудаас ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч, холбогдох зөвшөөрлүүдийг олгон, Бүртгэлийн хорооны хурлын шийдвэрээр тухайн компаниудын бүртгэлийн баримт бичгийг хянах гишүүдийг томилуулсан.

Дээрх 2 компаниас Анд-Энерги компани андеррайтерийн Бумбат-Алтай ҮЦК-тай хамтран үнэт цаасаа Биржид бүртгүүлэх хүсэлт, бүртгэлийн баримт бичгийн анхны болон эцсийн хувилбаруудыг холбогдох журмын дагуу бүрдүүлэн ирүүлснийг хүлээн авч хянан, санал дүгнэлтийг Бүртгэлийн хорооны хурлаар 2 удаа хэлэлцүүлэв.

ТУЗ-ийн хурлаар Бүртгэлийн хорооны гишүүдийн тоог өргөтгөн баталж, одоогоор 19 гишүүнтэй болоод байна. Анд-энерги ХК-ийн үнэт цаасны материалыг хянах, бүртгэлтэй холбоотой шийдвэр гаргах ажлын хэсэгт Бүртгэлийн хорооны гишүүн Г.Оюунгэрэл, Ж.Дэлгэрсайхан, П.Болормаа нар орж ажиллалаа.

Бүртгэлийн хорооны нарийн бичгийн даргаар 2017 оны 9 дүгээр сараас Бизнес хөгжлийн албаны

мэргэжилтэн Т.Мөнхжавхлан томилогдон ажиллаж байна. Тайлант хугацаанд Бүртгэлийн хорооны хурал 4 удаа хуралдаж, нийт 7 асуудал хэлэлцсэнээс хуралд оролцсон саналын эрхтэй гишүүдийн олонхийн саналаар 3 тогтоол гарган баталгаажуулав. Үүнд:

- о “Анд-Энерги” ХХК болон “Атмор” ХХК-ийн үнэт цаас бүртгүүлэх өргөдлийг хүлээн авч бүртгэлийн баримт бичгийг хянаж холбогдох шийдвэр гаргах гишүүдийг томилох тухай,
- о “Анд-Энерги” ХК-ийн гаргасан 78,070,758 ширхэг энгийн хувьцааг Монголын үнэт цаасны биржийн үндсэн талбарт бүртгэх тухай,
- о “Анд-Энерги ХК-ийн үнэт цаасыг нийтэд санал болгох Бүртгэлийн баримт бичиг буюу “Үнэт цаасны танилцуулга”-ыг эцэслэн батлах тухай.

Мөн СЗХ-ны 2017 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн 176 тоот тогтоол гарч Анд-Энерги ХК-ийн үнэт цаасын Хорооны нийтэд санал болгох үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд бүртгэх шийдвэр гаргасан байна.

Дээрх шийдвэрүүдийг үндэслэн Анд-Энерги ХК-тай Бүртгэлийн гэрээ байгуулан, Гэрээний ерөнхий нөхцлийн хэрэгжилтийг хангах зорилгоор хувьцааны мэдээ, тайланг нийцүүлэгчтэй хамтран боловсруулж, олон нийтэд мэдээлэх ажлыг гүйцэтгэж байна.

### **Маркетинг, олон нийттэй харилцах:**

Байгууллагын маркетинг, олон нийттэй харилцах ажлын хүрээнд Биржийн үйл ажиллагааг сурталчлах, шинэ үнэт цаасыг олон нийтэд танилцуулах маркетингийн хөтөлбөр, арилжааны албан ёсны нээлтийн ёслол, арга хэмжээний танилцуулга материал, сургалт, хэвлэл мэдээллийн байгууллагад зориулсан мэдээ мэдээллийг боловсруулах зорилтуудын хүрээнд доорх ажлуудыг хариуцан гүйцэтгэлээ. Үүнд:

- Маркетингийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулсан.
- Биржийн бүх бланк, тамга тэмдгийн загварыг программ дээр бэлтгэсэн.
- Үндсэн үйл ажиллагааны программ хангамж дахь мэдээллийн урсгалын дизайн бэлтгэх, icon гаргах ажилд оролцсон.
- Анд-Энерги ХК-ийн Үнэт цаасны танилцуулгын нугалбар, эх бэлтгэлд зөвөлгөө өгч, хэвлэлтийг хянасан.
- Биржийн гарын авлагуудын эх бэлтгэл, хэвлэлтийг хариуцаж ажилласан.
- Програмуудын шинэчилсэн туршилтанд оролцож тест хийсэн.
- Москвагийн биржийн вэб-ийг орчуулж, тайлбарт загвар бэлтгэсэн.
- Байгууллагын твиттер, фэйсбүүк хуудсыг шинэчлэн, зураг, сурталчилгааны материалын эх бэлтгэсэн.
- Өдрийн сонин, Өнөөдөр сонинтой гэрээ байгуулан өдөр бүрийн үнэт цаасны арилжааны мэдээ, хөрөнгө оруулагчдад зориулсан бусад мэдээ мэдээллийг 2017 оны 11 сарын 24-нөөс хойш он дуустал ажлын өдөр бүр нийтлүүллээ.
- Биржийн нээлтийн ёслолын үйл ажиллагааны бэлтгэлд оролцож, дизайн, дурсгалын зүйлийн эх бэлтгэлийг хийсэн.

### **Бусад:**

- Монгол Улсын хууль тогтоомж, гадаадын биржүүдийн зохицуулалт, дүрэм журмыг судалсан.
- СЗХ-ны боловсруулсан журмын төслүүдэд санал өгсөн.



## 2.2. Үнэт цаасны арилжаа

### *Анхдагч зах зээл*

СЗХ-ны 2017 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн 176, Биржийн Бүртгэлийн хорооны 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 17/02 тоот тогтоолуудыг үндэслэн Анд-Энерги хувьцаат компанийн анхдагч зах зээлийн арилжааг 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгууллаа. Анхдагч зах зээлийн арилжааг Үнэт цаасны танилцуулгад заасан аргачлалын дагуу захиалгын бүртгэлийн аргаар явуулсан бөгөөд нийт 26 544 058 ширхэг энгийн хувьцааг нэг бүрийг нь 60 төгрөгөөр нийтэд санал болгосноос 40 793 758 сая ширхэг хувьцаа худалдан авах нийт 2 447 625 480 төгрөгийн санал ирүүлсэн байна. Нийт захиалгаас андеррайтер Бумбат-Алтай ҮЦК өөрийн 700.0 сая төгрөгийн захиалгыг буцаан татаж, үнэт цаасны танилцуулгад заасны дагуу 10.0 сая төгрөг хүртэл болон нийт хувьцааны 5-аас дээш хувийг худалдан авахаар ирүүлсэн захиалгуудыг бүтнээр, бусад захиалгыг хувь тэнцүүлэх аргаар хуваарилалт хийж, нийт 419 хувьцаа эзэмшигч Анд-Энерги хувьцаат компанийн хувьцааг анхдагч зах зээлээс худалдан авсан.

### *Хоёрдогч зах зээл*

Анд-Энерги ХК-ийн анхдагч зах зээлийн арилжааны тайланг холбогдох журмын дагуу СЗХ-нд хүргүүлэн, СЗХ-ны 2017 оны 11 дүгээр сарын 08-ний өдрийн 1/3261 тоот албан бичгийн дагуу хоёрдогч зах зээлийн арилжааг 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр нээсэн болно.

2017 онд нийт 34 өдрийн арилжаа явагдаж, 1 454 300 ширхэг хувьцааг 86 549 390 төгрөгөөр арилжсан байна. Арилжаанд Бумбат-Алтай, Батс, Дэлгэрхангай секюритис, Булган брокер, Голомт капитал, Гаули, Зэргэд компаниуд оролцсоноос хамгийн өндөр үнийн дүн бүхий гүйлгээг Дэлгэрхангай секюритис, Булган брокер үнэт цаасны компаниуд гүйцэтгэлээ.

Тайлант хугацаанд Анд-Энерги ХК-ийн хувьцааны дээд ханш 69 төгрөг, доод ханш 49 төгрөг, хаалтын ханш 50 төгрөг байлаа.

Хоёрдогч зах зээлийн арилжаанд харилцагч шууд оролцох зориулалт бүхий windows, ios, android үйлдлийн систем дээр ажиллах вэб аппликэшний захиалга боловсруулах, бодлогын даалгавар гаргах ажлыг эхлүүлсэн.

### *Арилжааны үе, арга, үнийн хэмжээс, ханшийн хэлбэлзэл*

“Монголын үнэт цаасны биржийн арилжааны журам”-ын дагуу үнэт цаасны арилжааг нээлт, үндсэн болон хаалтын үеүдэд хуваан явуулж байна. Гүйцэтгэх захирлын тушаалаар арилжааны нээлтийн үе ажлын өдөр бүрийн 10.50-10.59 цагт, үндсэн үе 11.00-11.50 цагт, хаалтын үе 11.50-12.00 цагийн хугацаанд тус тус явагдсан. Нээлт хаалтын үеүдийг дуудлага арилжааны буюу тэнцвэрт үнийн аргаар, үндсэн үеийг үргэлжилсэн арилжааны аргаар, хамгийн бага үнийн хэмжээсийг 10 мөнгөөр, үнэт цаасны лотыг 100 ширхэгээр, тухайн өдрийн арилжааны нээлтийн ханшийн хэлбэлзлийг өмнөх өдрийн хаалтын ханшаас 10 хувиар, тухайн арилжааны өдрийн ханшийн хэлбэлзлийг сүүлийн хэлцлээс 5 хувиар тус тус тогтоон мөрдөж ирлээ.

### *Зах зээл үүсгэгч*

“Монголын үнэт цаасны биржийн арилжааны журам”-ын 6 дугаар бүлэгт заасны дагуу Дэлгэрхангай секюритис ҮЦК-тай Зах зээл үүсгэх гэрээг 2017 оны 11 дүгээр сарын 15-ны

өдөр байгуулан, гэрээг дүгнэж ажиллалаа. Зах зээл үүсгэх гэрээний хавсралт Тусгай гэрээнд заасан хугацаанд Зах зээл үүсгэгч нь 20 удаагийн арилжаанд оролцсон бөгөөд үүнээс 11 удаад нь гэрээний нөхцлийг бүрэн биелүүлж, 9 удаад нь хагас биелэлттэй оролцсон байна.

### *Арилжааны мэдээ мэдээлэл*

СЗХ-ны “Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сангийн журам”-ын 2 дугаар бүлгийн 2.2, дахь заалтын дагуу 2017 оны 11, 12 дугаар сарын арилжааны мэдээллийг холбогдох маягтаар бэлтгэн СЗХ-нд хүргүүлээ.

Арилжааны өдөр тутмын мэдээллийг market.msx.mn вэб хаягаар болон өдөр тутмын Өнөөдөр, Өдрийн сонин хэвэлээр дамжуулан олон нийтэд хүргэсэн. Мөн дээрх вэб хуудсанд үнэт цаас гаргагч Анд-Энерги ХК-ийн олон нийтэд хүргэх холбогдох мэдээллийг тогтмол оруулж ирсэн. Мөн www.marketinfo.mn сайттай гэрээ байгуулан арилжааны мэдээлэл хүргүүлж байна.

### *Арилжааны хяналт*

“Монголын үнэт цаасны биржийн хяналтын журам”-ын дагуу үнэт цаасны арилжаанд хяналт тавьж байна. “Дотоод мэдээлэл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам”-ын дагуу үнэт цаасны мэдээллийн сан бүрдүүлэн, арилжаанд хяналт тавьж байна. Үнэт цаасны арилжааг онлайн хянах зориулалт бүхий 1 терминалыг СЗХ-нд байршуулан СЗХ-ны Үнэт цаасны газар хяналт тавьж байна.

## **2.3. Төлбөр тооцоо эрсдэлийн удирдлага**

“Монголын үнэт цаасны бирж” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр баталсан “Монголын үнэт цаасны биржийн тооцооны үйл ажиллагааны журам”-д заасны дагуу арилжаанд оролцогчдын төлбөр тооцоог Төлбөр тооцоо эрсдэлийн удирдлагын алба хариуцан гүйцэтгэж байна. Дээрх журмын 5 дугаар бүлгийн 5.19-т заасны дагуу арилжааны төлбөр тооцоог тухайн хэлцэл хийсэн өдрөөс хойш хуанлийн 3 хүртэл хоногт багтаан гүйцэтгэх бөгөөд мөн журмын 5 дугаар бүлгийн 5.13, 5.15-д заасны дагуу “Төлбөр гүйцэтгэх мэдээ”-г үндэслэн Биржийн Тооцооны гишүүн компаниуд өөрийн харилцагч Үнэт цаасны компанийн төлбөр тооцоог гүйцэтгэж байна.

### *Тооцооны гишүүн, тооцооны үйл ажиллагаа*

“Монголын үнэт цаасны бирж” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 29 тоот тогтоолоор “Нэрэн клиринг” ХХК, “Харз трейд” ХХК-иудыг Биржийн тооцооны гишүүнээр элсүүлэн, гэрээний дагуу хамтран ажиллаж байна. Эдгээр тооцооны гишүүд Биржийн арилжаанд оролцогч гишүүн Үнэт цаасны компанитай “Клирингийн үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г байгуулан ажиллаж байна.

2017 онд “Нэрэн клиринг” ХХК 7 үнэт цаасны компанитай, “Харз трейд” ХХК 2 үнэт цаасны компанитай “Клирингийн үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулж, 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 173,098,780 төгрөгийн төлбөр гүйцэтгэсэн байна. Үүнээс “Нэрэн клиринг” ХХК 122,076,440 төгрөгийн, “Харз трейд ББСБ” ХХК 51,022,340 төгрөгийн төлбөр гүйцэтгэжээ.

Холбогдох журмын дагуу гишүүн үнэт цаасны компаниуд тооцооны гишүүний дансанд, тооцооны гишүүд Биржид төлбөр гүйцэтгэхтэй холбоотой барьцаа баталгаа гаргах, төлбөрийн дүн өндөр тохиолдолд гишүүн үнэт цаасны компани тооцооны гишүүн хооронд болон тооцооны гишүүн Биржийн гэрээт арилжааны банк хооронд репо хэлцэл хийхээр зохицуулан хамтын гэрээнүүд хийгдээд байна. Монголын үнэт цаасны бирж хаалттай хувьцаат компанийн хэлбэрт шилжин, хувьцаагаа ҮЦТХТ-д хадгалуулснаар компанийн хувьцааг тооцооны гишүүний барьцаа хөрөнгөд ашиглах боломжийг бүрдүүллээ. Мөн Биржид бүртгэлтэй Анд-Энерги ХК болон Засгийн газрын үнэт цаасыг барьцаа хөрөнгөд тооцож байна.

2017 оны жилийн эцсийн байдлаар нийт 346 хэлцэл хийгдсэнээс 90,000 ширхэг үнэт цаасны төлбөр 5,570,800 төгрөгийг Т+3 хугацаанд төлөх 6 нээлттэй позиц үүсгэж позицоо хугацаанд нь бүрэн хаасан байна. Мөн гишүүн компаниуд тооцооны гишүүдтэй 9,384,020 төгрөгийн репо хэлцэл хийжээ. 2017 онд өөрийн эзэмшилд байхгүй үнэт цаасыг худалдах буюу short sell захиалга оруулж, позиц нээсэн тохиолдол гараагүй.

Дээр дурдсан төлбөр тооцооны үйл ажиллагаатай холбоотой анхан шатны маягтуудыг боловсруулах, батлуулах, программчлах, гишүүдэд танилцуулах, ашиглах ажлууд хийгдэж байна.

### *Эрсдэлийн удирдлага*

Үнэт цаасны арилжаанд дэнчин ашиглан захиалга өгөх, төлбөр тооцоог Т+3 хүртэл хугацаанд төлөх, short sale буюу хувьцаа зээлээр худалдахтай холбоотой эрсдэлүүдийг удирдан хэрэгжүүлж байна. Тухайлбал арилжааны дүн, ханшийн өөрчлөлтөөс хамааруулан гишүүдийн барьцаа хөрөнгийн хэмжээг 2.5 сая төгрөг болгон бууруулах, үнэт цаасны үлдэгдлийг шалгасны үндсэн дээр зарах захиалгын дэнчинг чөлөөлөх, 2017 оны 11, 12 дугаар сарын арилжааны мэдээлэлд үндэслэн ханшийн өөрчлөлтийн симуляци тооцоолол гаргах ажлуудыг гүйцэтгэлээ. Бирж дээр хийгдсэн арилжааны хэлцэл, позицтой холбоотой төлбөрийн эрсдэл гараагүй болно.

### *Мэдээлэл*

СЗХ-ны “Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сангийн журам”-ын 2 дугаар бүлгийн 2.3 дахь заалтын дагуу 2017 оны 11, 12 дугаар сарын төлбөр тооцооны мэдээллийг холбогдох маягтаар бэлтгэн Хороонд хүргүүллээ.

Төлбөр тооцооны зохицуулалтыг сайжруулах, төлбөр тооцоо гүйцэтгэх уян хатан байдлыг нэмэгдүүлэх зорилгоор “Монголын үнэт цаасны биржийн тооцооны үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн боловсруулж байна. Энэ журмыг батлагдсанаар төлбөр тооцоог илүү хялбар аргаар, түргэн шуурхай гүйцэтгэх, төлбөрийн эрсдэлийг бүрэн удирдах боломжтой болно.

## **2.4. Мэдээллийн технологи, программ хангамж**

Мэдээллийн технологийн алба (МТА) нь 2017 онд албаны захирал, ахлах мэргэжилтний орон тоо, мөн техник хангамж хариуцсан гэрээт ажилтан, программ хангамжийн гэрээт байгууллагатай хамтран үйл ажиллагаа явууллаа.

Тус алба нь 2017 онд Биржийн мэдээллийн системийн загварыг тодорхойлох, арилжааны программыг бүрэн ажиллагаанд оруулах, түүнтэй холбоотой дагалдах программуудыг боловсруулж нэвтрүүлэх, тэдгээрийн найдвартай ажиллагааг ханган ажиллах зорилт тавин

ажилласан. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Компанийн вэб сайт (msx.mn)-ыг гүйцэтгэгч талаас хүлээн авсан.
- Арилжааны програм (Msx Trader)-ын хөгжүүлэлтийн ажлыг дуусгаж, туршин сайжруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлэв.
- Сүлжээний тоног төхөөрөмж, сервер компьютерүүдийг хүлээн авч суурилуулан тохируулгыг хийж ажлын горимд оруулав. Дараах төхөөрөмжүүд ашиглагдаж байна. Үүнд:
  - o Арилжааны өгөгдлийн сангийн сервер - 2;
  - o Арилжааны системийн сервер - 2;
  - o Вэб сервер - 1;
  - o Өгөгдөл хадгалагч - 1;
  - o Сүлжээний замчлагч төхөөрөмж - 2;
  - o Сүлжээний холбогч төхөөрөмж - 2.
- Юнивишн болон Мобинэт компаниудтай гэрээ байгуулан, интернет урсгалд шилэн кабелиар холбогдож, тохируулгууд бүрэн хийгдсэн.
- Арилжаанд оролцогч талуудад зориулсан сургалтын үеэр мэдээллийн системийн бүтэц, программ ашиглах зааврыг танилцуулсан.
- Арилжаанд оролцогч талуудад арилжааны програм (Msx Trader) болон брокерийн ажлын програм (Back Office)-уудыг суурилуулан ашиглалтанд оруулсан.
- Гэрээт байгууллад дараах программыг захиалан, хүлээн авч, үйл ажиллагаанд нэвтрүүлэв. Үүнд:
  - o Биржийн дотоод үйл ажиллагааг автоматжуулахад зориулан office.msx.mn вэб программ;
  - o Биржийн оролцогч талуудтай харилцахад зориулан member.msx.mn вэб програм;
  - o Арилжааны мэдээ, ҮЦ гаргагч компанийн мэдээллийг түгээх зориулалт бүхий market.msx.mn вэб програм.
- ҮЦГХТ-тэй мэдээлэл солилцох гэрээ байгуулж, 2 талын шууд холболт бүхий сүлжээ үүсгэн, мэдээллийн системүүдийн хооронд мэдээлэл солилцох программ нэвтрүүлсэн.
- Арилжааны мэдээллийг олон нийтэд түгээх зорилгоор программын гарц (API)-ыг хөгжүүлж, marketinfo.mn вэб сайтад мэдээлэл авах эрх олгосон.

Программ хангамж хөгжүүлэх болон мэдээллийн системийн аюулгүй найдвартай байдлыг хангах үүднээс шинээр дараахь программ хангамж болон лизенц худалдан авсан. Үүнд:

- Вэб сайтын нууцлал хангагч (SSL);
- Имэйл илгээх програм (ElasticEmail);

- Вэб сайтад хүснэгтэн мэдээлэл харуулах програм (HandsonTable);
- Өгөгдлийн сангийн сервер програмын лизенц (SQL Server).


Мөн бусад алба нэгжийг мэдээллээр хангах, шаардлагатай мэдээллийг боловсруулж гаргахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Биржийн үйл ажиллагааны журамыг шинэчлэн сайжруулахтай холбоотой мэдээллийн системийг шинэчлэн өөрчлөх ажлын даалгавар гаргах ажлууд хийгдэж байна.

### 3. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

#### Санхүүгийн байдлын тайлан


Тайлант хугацаанд компани 1,013.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт татаж, эзэмшигчдийн өмчийг 516.5 сая төгрөгөөр нэмэгдүүлснээр хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн 4,187.0 сая төгрөгт хүрсэн байна.



2016 онд биет бус хөрөнгө нэмж бүртгэн, хувьцааны нэрлэсэн үнийг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор 2015-2016 онд хувь нийлүүлсэн хөрөнгө 10 дахин өсөв.

Капиталын бүтцээр нь авч үзвэл 2017 оны аудитлагдаагүй санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр нийт хөрөнгийн 86.5 хувийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байгаа нь 2016 онтой харьцуулахад 12.2 хувиар өссөн үзүүлэлт юм.

Өр төлбөр болон өөрийн хөрөнгийн харьцуулалт /сая төг/



Богино хугацаат өр төлбөрийн дүн тайлант хугацаанд 417.8 сая төгрөгөөр буурсан.

2017 оны жилийн эцсийн байдлаар нийт 34 удаагийн арилжааг 7 гишүүн, 2 тооцооны ерөнхий гишүүний оролцоотойгоор явуулсан бөгөөд Биржийн холбогдох журмын дагуу тооцооны гишүүдийн байршуулсан барьцаа хөрөнгийн үлдэгдэл 20.0 сая төгрөг, харилцагч, брокерын компаниудын байршуулсан дэнчингийн үлдэгдэл 6.4 сая төгрөгийг өр төлбөрөөр тайлагнаж, мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тодруулга хийсэн.

Арилжаа, төлбөр тооцооны системийн ашиглалттай холбоотойгоор тайлант онд 49,896.15 ам.долларын үнэ бүхий сервер тоног төхөөрөмжийн багцыг худалдан авч ашиглаж эхэлснээс гадна хүний нөөц нэмэгдүүлж, үйл ажиллагаа эхлүүлсэнтэй холбоотойгоор бусад хөрөнгө

нэмэгдэж, эргэлтийн бус хөрөнгийн дүн 4,568.0 сая төгрөгт хүрсэн байна. Нийт хөрөнгөд эргэлтийн хөрөнгийн эзлэх хувь буюу эргэлтийн харьцаа өмнөх оны үзүүлэлтээс 2.0 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант онд эргэлтийн хөрөнгө өмнөх онтой харьцуулахад 40 орчим хувиар өссөн бөгөөд энэ өсөлтөнд мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 89 хувийн өсөлт, урьдчилж төлсөн зардал, тооцооны 37 хувийн өсөлт болон авлагын 23 хувийн өсөлтүүд тус тус нөлөөлжээ.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн бүрэлдэхүүнд арилжааны төлбөр тооцоотой холбоотойгоор арилжаанд оролцогчдын байршуулсан дэнчин, барьцааны мөнгөн үлдэгдэл болох 26.4 сая төгрөгийн үлдэгдэл агуулагдаж байгаа юм.


### Орлогын дэлгэрэнгүй тайлангийн үзүүлэлтүүдийн тухай

Тайлант онд Монголын үнэт цаасны бирж анхны арилжаагаа явуулж, нийт 657.4 мянган төгрөгийн шимтгэлийн орлоготой ажилласан бөгөөд нийт орлогын 73.7 хувийг арилжааны шимтгэлийн орлого, 26.3 хувийг тооцооны шимтгэлийн орлого бүрдүүлж байна.

Компанийн ТУЗ-ийн шийдвэрээр үнэт цаасны бүртгэлийн шимтгэл, гишүүний элсэлтийн болон жилийн хураамж гэх мэт зарим орлого төвлөрүүлэх хугацааг түр хойшлуулсан, мөн IPO гаргахаар төлөвлөсөн компаниудын бэлтгэл ажлын явц удааширснаас хамааран орлогын гүйцэтгэл төсөвлөсөн хэмжээнд хүрээгүй болно.

Зардлын хувьд 92.7 хувийн гүйцэтгэлтэй буюу 375.6 сая төгрөгийн үйл ажиллагааны зардалтай ажилласан. Үүний 17 хувийг үндсэн ажиллагсдын цалин хөлс, 25 хувийг мэдээллийн технологи, хууль, аудит, үнэлгээ гэх мэт мэргэжлийн үйлчилгээний зардал, 20 хувийг түрээсийн зардал, 11 хувийг үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, 11 хувийг зээлийн хүүгийн зардал тус тус бүрдүүлж байна. Жилийн эцсийн байдлаар урт хугацаат зээлүүдээс өөр хүү тооцох зээлийн үлдэгдэл байхгүй.

Үйл ажиллагааны зардлын задаргаа



2017 оны аудитлагдаагүй санхүүгийн тайлангаар 375.6 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал гарсан нь өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 5 хувиар буурсан үзүүлэлт байна.

*Голлох санхүүгийн үзүүлэлтүүд-Аудитлагдаагүй /сая төгрөгөөр/*

Санхүүгийн байдлын тайлан

Үзүүлэлтүүд	2016	2017
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>306.89</b>	<b>420.22</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	16.29	30.80
Тусгаарласан мөнгө /дэнчин, барьцаа/	-	26.41
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	212.18	290.53
Бусад эргэлтийн хөрөнгө	78.42	98.89
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>4,454.00</b>	<b>4,567.98</b>
Үндсэн хөрөнгө	44.00	149.60
Биет бус хөрөнгө	4,410.00	4,418.39
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>4,760.89</b>	<b>4,988.20</b>
<b>Өр төлбөр</b>	<b>1,088.91</b>	<b>671.13</b>
Дэнчин, барьцаа	-	26.41
Цалингийн өглөг	103.04	100.18
Татварын өр	19.99	9.15
НДШ-ийн өр	42.20	-
Бусад өглөг	923.68	335.39
Урт хугацаат зээл	-	200.00
<b>Эзэмшигчдийн өмч</b>	<b>3,671.98</b>	<b>4,317.07</b>
Хувь нийлүүлсэн хөрөнгө	3,670.50	4,187.00
Нэмж төлөгдсөн капитал	360.50	877.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	231.00	231.00
Эздийн өмчийн бусад хэсэг	70.00	50.00
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(660.02)	(1,027.93)
<b>Нийт өр төлбөр ба эздийн өмч</b>	<b>4,760.89</b>	<b>4,988.20</b>

Орлогын дэлгэрэнгүй тайлан

Үзүүлэлтүүд	2016	2017
Борлуулалтын орлого	-	0.66
Борлуулалтын өртөг	-	-
<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>-</b>	<b>0.66</b>
Хүүний орлого	-	5.51
Ерөнхий ба удирдлагын зардал	394.28	375.63
Бусад зардал	0.01	0.72
Гадаад валютын хөрвүүлэлтийн олз (гарз)	0.01	2.82
<b>Татварын өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(394.29)</b>	<b>(367.36)</b>
Орлогын татварын зардал	-	0.55
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(394.29)</b>	<b>(367.91)</b>



## Мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлтүүд	2016	2017
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Мөнгөн орлогын дүн (+)	7.79	1,868.19
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	1.16
Бусад мөнгөн орлого	7.79	1,867.03
Мөнгөн зарлагын дүн (-)	182.60	2,203.28
Ажиллагчдад төлсөн	85.59	72.63
НДБ-д төлсөн	9.00	54.57
Бараа материал авахад төлсөн	1.70	14.53
Ашиглалтын зардалд төлсөн	41.27	86.61
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1.62	0.40
Хүүний төлбөрт төлсөн	7.00	42.98
Татварын байгууллагад төлсөн	5.47	15.53
Бусад мөнгөн зарлага	30.95	1,916.03
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(174.81)</b>	<b>(335.09)</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Мөнгөн орлогын дүн (+)	-	4.56
Хүлээн авсан хүүний орлого	-	4.56
Мөнгөн зарлагын дүн (-)	10.58	520.38
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	10.58	126.52
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		8.39
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		385.47
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(10.58)</b>	<b>(515.82)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Мөнгөн орлогын дүн (+)	227.50	962.90
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	27.50	275.90
Хувьцаа болон өмчийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	200.00	687.00
Мөнгөн зарлагын дүн (-)	27.50	95.50
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	27.50	95.50
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>200.00</b>	<b>867.40</b>
Ханшийн зөрүү	0.01	(1.99)
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>14.62</b>	<b>14.51</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1.67	16.29
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	16.29	30.80

## 4. ДҮГНЭЛТ

“Монголын үнэт цаасны бирж” ХК-ийн хувьд 2017 он нь анхны бүтээгдэхүүнээ зах зээлд гаргаж үнэт цаасны арилжаагаа нээсэн, тооцооны шинэ үйлчилгээ нэвтрүүлсэн, үндсэн үйл ажиллагааны орлого бүрдүүлэлт эхэлсэн, өр төлбөрийг бууруулсан, нэмэлт хөрөнгө оруулалт татаж хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнг 4.18 тэрбум төгрөгт хүргэж өсгөсөн, хаалттай хувьцаат компанийн хэлбэрт шилжсэн, бүртгэлтэй компани, нийцүүлэгч, төлбөр гүйцэтгэгч банк, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, арилжааны болон тооцооны гишүүд зэрэг хамтран ажиллах байгууллагуудын тоо нэмэгдсэн зэрэг ололт амжилтаар дүүрэн жил болж өнгөрлөө.

Хэдийгээр бүтээгдэхүүний тоо цөөн, арилжааны дүн бага байгаа боловч маржин арилжаа, зах зээл үүсгэгч, тооцооны үйл ажиллагаа, тооцооны гишүүнчлэл, төлбөр тооцооны Т+3 горим, репо арилжаа, эрсдэлийн удирдлага зэрэг цоо шинэ үйлчилгээг Монгол Улсад анхлан туршиж, практикт амжилттай нэвтрүүлээд байна.

Анд-Энерги компани Биржийн дүрэм журмыг хүлээн зөвшөөрч, үнэт цаас гаргах замаар хөрөнгө оруулалт татах гарааг эхлүүлэн, 1.59 тэрбум төгрөгийн эх үүсвэр татаж чадсан нь нийгэм эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалд манай байгууллагын үйл ажиллагаа эрэлттэй байгааг харуулж байна. Гэвч хөрөнгийн захын тухай олон нийтийн зөв ойлголт бага, бизнесийн байгууллагуудын засаглал сул, өмчлөлийн маргаантай, санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг мөрддөггүйгээс шалтгаалан үнэт цаасаа нийтэд санал болгох бэлтгэл ажилд хугацаа алдсан хэвээр байна. Тухайлбал, 2016 оны 12 сараас хамтран ажилласан 2 компанийн үнэт цаас гаргах үйл ажиллагаа хойшлоод байна. Түүнчлэн гишүүн байгууллагын хүний нөөц, санхүүгийн чадавх сул байгаа нь зах зээл үүсгэх, номиналь дансны эрх авах, төлбөр тооцоог Т+3 горимоор гүйцэтгэх, репо хэлцэл хийх зэрэг шинэ ажил үйлчилгээг нэвтрүүлэхэд хүндрэл учруулж байна.

Тайлант хугацаанд төлөвлөсөн хэмжээгээр шинэ бүтээгдэхүүн гаргаж чадаагүй, үндсэн үйл ажиллагааны орлого бага байснаас шалтгаалан ихэнх зардлыг нэмэлт хувьцааны хөрөнгө оруулалт, зээлийн эх үүсвэрээр санхүүжүүллээ.

Иймд 2018 онд бүтээгдэхүүний тоо хэмжээ, арилжааны дүнг нэмэгдүүлэх, гишүүдийн чадавхийг сайжруулах, харилцагчдад хүргэх үйлчилгээг шуурхай болгох зорилгоор OMS буюу онлайн арилжааны систем нэвтрүүлэх, төлбөр тооцооны аргачлалыг боловсронгуй болгох, NASDAQ группийн программ хангамжийг суурилуулах ажлыг эхлүүлэх, байгууллагын урсгал зардлыг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрэн санхүүжүүлэх зорилт тавигдаж байна.





**МОНГОЛЫН  
ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ**

Mongol Securities Exchange

**Улаанбаатар-14191, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,  
Бээжингийн гудамж, GB Plaza, 703 тоот**

**Вэб: [www.msx.mn](http://www.msx.mn)**

**Утас: 7000-0501**